



УЛААНБААТАР ХОТЫН  
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН  
ТУШААЛ

2019 оны 07 сарын 03 өдөр

Дугаар А/195

Улаанбаатар хот

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.3, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 36,37,38 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан "Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам"-ын 2 дугаар хэсгийн 2.4.1, Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2019 оны 47 дугаар тушаалаар Төрийн байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, Нэгжийн болон Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах загвар, арга аргачлал батлагдсантай холбогдуулан дээрх журмуудыг ашиглахад төрийн албан хаагчдад арга зүйн туслалцаа үзүүлэх, нэвтрүүлэх чиглэлээр 2019 оны 07 дугаар сарын 05-ны өдөр сургалт зохион байгуулахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс /Э.Энхцэцэг/-т даалгасугай.

2. Сургалт зохион байгуулах багшийн зардал болох 50000 /тавин мянга/ төгрөгийг Дотоод журмын 6 дугаар хэсгийн 6.35 дахь заалтын дагуу бусад зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч /Б.Цэрмаа/-д зөвшөөрсүгэй.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР  
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ  
ДАРГА  Т.ГАНТӨМӨР

